

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 03 сарын 11-ны өдөр

Дугаар...

БА-073/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Багануур дүүргийн 1 дүгээр хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 12 давхар, 1 блок, 8 (найм) автомашины дулаан зогсоолтой, 60 (жар) айлын орон сууцны зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дүгээр захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 14 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 02 сарын 14-ний өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

- 2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2023/05/12 огноо, 0012734 дугаар, БАЗГ2023/232
- 2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр: AR-22/03-01
- 2.3. Захиалагч: Сэтэрт Групп ХХК, 9011581038 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6025161 регистрийн дугаартай, Хаяг: Баянгол дүүрэг, 17р хороо, амарсанаа 73 21 тоот, 88061406 холбоо барих утас, setert.group11@gmail.com цахим хаяг;
- 2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Сэтэрт Групп ХХК, 9011581038 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6025161 регистрийн дугаар, БУ11-360/21 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаартай, Хаяг: Баянгол дүүрэг, 17р хороо, амарсанаа 73 21 тоот, 88061406 холбоо барих утас, setert.group11@gmail.com цахим хаяг;
- 2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Дөлгөөн илч ХХК, 9011845643 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6949991 регистрийн дугаар, 2228/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Сонгинохайрхан дүүрэг, 10-р хороо, Зүүнбаян-Уул, 7-27а тоот, 99877442 холбоо барих утас;

Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Айникс Инженеринг ХХК, 9011426001 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5731291 регистрийн дугаар, БУ17-345/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Сонгинохайрхан дүүрэг, 30-р хороо, хамба 1, 21 тоот, 99113045 холбоо барих утас;

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах комисс

Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Эс ар трэйд ХХК, 9019097163 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6116612 регистрийн дугаар, ӨБ16-1148/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, "Алтай тауэр" 2-р давхар, 204 тоот, 77232233 холбоо барих утас;

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Архидеа ХХК, 9011768046 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6353169 регистрийн дугаар, ЗТ11-632/20 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Баянгол дүүрэг, 7-р хороо, 3-р хороолол, 12 байр, 33 тоот, 99105431 холбоо барих утас,

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага:

Сэтэрт Групп ХХК, 9011581038 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6025161 регистрийн дугаар, БУ11-360/21 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаартай, Хаяг: Баянгол дүүрэг, 17р хороо, амарсанаа 73 21 тоот, 88061406 холбоо барих утас, setert.group11@gmail.com цахим хаяг;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1 Энэ өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 12 давхар, 1 блок, 8 (найм) автомашины дулаан зогсоолтой, 60 (жар) айлын орон сууцны зориулалттай барилгын байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

ХЯНАЛТ ШАЛГА
ГАЗАР

Барилга байгууламжийг
орлуулах коми

- а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ажлын 14 хоногийн дотор багтаан шилжүүлэх;
- б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3 Ашиглагч байгууллагад:

- а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;
- б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
- в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4 Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 5 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 32 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1 Өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 12 давхар, 1 блок, 8 (найм) автомашины дулаан зогсоолтой, 60 (жар) айлын орон сууцны зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга: Сэтэрт Групп ХХК-ийн гүйцэтгэх захирал




(Г.Өлзийбуян)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



БАГАНУУР ДҮҮРГИЙН 1 ДҮГЭЭР ХОРОО, СЭТЭРТ ГРУПП ХХК-ИЙН
ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬТОЙ 12 ДАВХАР, 1 БЛОК, 8 АВТОМАШИНЫ ДУЛААН
ЗОГСООЛТОЙ, 60 АЙЛЫН ОРОН СУУЦНЫ ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГЫГ
АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 02 дугаар сарын 14



Багануур дүүргийн 1 дүгээр хороо, Сэтэрт Групп ХХК-ийн захиалгатай, зоорьтой 12 давхар, 1 блок, 8 автомашины дулаан зогсоолтой, 60 айлын орон сууцны зориулалттай барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгыг ашиглалтанд оруулах комисс 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдөр 15 цагт 14 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 17 цагт дуусав.

Хуралд:

- | | |
|--|----------------|
| 1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч | А.Мөнгөн |
| 2. Комиссын нарийн бичгийн дарга: Захиалагч “Сэтэрт Групп” ХХК Гүйцэтгэх захирал | Г.Өлзийбуян |
| 3. Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс Барилга техникийн хяналтын улсын /ахлах/ байцаагч | Н.Ёндонсамбуу |
| 4. Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандартын хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч | З.Очирпүрэв |
| 5. Багануур Дулааны сүлжээ ТӨХК Ерөнхий инженер | А. Лхамсүрэн |
| 6. Багануур цахилгаан түгээх сүлжээ салбар | Л. Анхбаяр |
| 7. Багануур мэдээлэл Холбоо Сүлжээ Ерөнхий инженер | Б. Наранбаатар |
| 8. Багануур ус ААТҮГ, Ерөнхий инженер | Ж. Мөнхцэцэг |
| 9. Онцгой байдлын ерөнхий газар, Барилгын зураг төсөл техникийн гүйцэтгэл хариуцсан ахлах мэргэжилтэн, Дэд хурандаа | Ч. Артаг |
| 10. Үндэсний Төв Архив, Зураг төслийн баримтын архивын ахлах архивч | Б. Оюунжаргал |
| 11. Барилгын хөгжлийн төв, Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн | О.Ундрах |
| 12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, төлөөлөл | Б.Ганбаатар |
| 13. Ашиглалт хариуцах байгууллага БНДС – ТӨХК Ерөнхий инженер | А. Лхамсүрэн |
| 14. Ашиглалт хариуцах байгууллага БНД Ус - ААТҮГ Ерөнхий инженер | Ж. Мөнхцэцэг |
| 15. Зураг төсөл зохиогч байгууллага Архидеа ХХК | Т. Дэлгэрдалай |
| 16. Барилгын ажил гүйцэтгэгч Сэтэрт Групп ХХК | Э.Цогхүү |

ИРЦИЙН БАЙДАЛ:

- Мэдэгдэл хүлээн авсан - 16
- Хүрэлцэн ирсэн - 16
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 16

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Багануур дүүргийн 1 дүгээр хороо, Сэтэрт Групп ХХК-ийн захиалгатай, зоорьтой 12 давхар, 1 блок, 8 автомашины дулаан зогсоолтой, 60 айлын орон сууцны зориулалттай барилгын ажлын гүйцэтгэл ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөв, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилгын техникийн хяналтын Улсын /ахлах/ байцаагч **Н. Ёндонсамбуу**

- Лифт албан шаардлага биелэлт үзүүлэх
- Бетон лабораторын шинжилгээ үзүүлэх
- Барилгын тухай хуулийн дагуу баталгаа албан тоот гүйцэтгэгч байгууллага ирүүлэх / 14.3, 14.6 / Дээвэр хийсэн компани үзүүлэх, хавсаргах
- Өөрчлөлтийн зураг хийлгэх, баталгаажуулах
- Нийтийн эзэмшлийн коридор хязгаарлагч хийх
- Гадна тохижилт ажил хийж дуусгах /баруун хэсэг/
- Айл өрх хаалга мөргөлдөж байгаад тайлбар албан тоот өгөх /цаашид арга хэмжээ авах/
- Зогсоол тоог тодорхой болгох / 8 авто машин зогсох боломжтой эсэх/
- Пандус хэсгийг бүрэн дуусгах
- Дээврийн хэсгийг бүрэн дуусгах
- Нийтийн эзэмшлийн цонх зургийн дагуу хийгдсэн эсэх / БА авчрах /
- Пандус хэсэгт хамгаалалт хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандартын хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч **З.Очирпүрэв**

- Гадна дулааны худагт агаар гаргагч хийх
- Узелийн шугам сүлжээ тоног төхөөрөмжинд хаягжуулалт, ус зайлуулах трап хийх
- Хими ус цэвэрлэгээний төхөөрөмжийг ашиглалтанд оруулах
- Цэвэр усны босоо шугаманд даралт тохируулагч хийх
- Халуун усны төгсгөлд хий авагч хийх
- Халаалтын коллекторт автомат хий авагч хийх
- Агаар сэлгэлтийн шахт бүрэн дулаалга, шугам хоолойнуудыг сэтгэн тороор таглах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Барилгын хөгжлийн төв, Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн **О.Ундрах**

- Шатны хонгилын цонхны нээлхийнд хязгаарлагч хийх



- Гадна зам, талбайн тэмдэг, тэмдэглэгээг / авто зогсоол, явган замын гарц / хийх
- Пандусын заслын ажлыг дуусгах саравчнд хамгаалалтын хашлага, хайс хийх
- 5-р давхрын бетоны бат бэхийн лабораторын дүгнэлтийг нөхөж үзүүлэх
- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасны дагуу норм, нормативын төлбөрийг тооцуулж төлөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Багануур мэдээлэл Холбоо Сүлжээ Ерөнхий инженер **Б. Наранбаатар**

- Холбооны өрөөнөөс босоо шугам хооронд кабелийн тавиур хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Багануур ус ААТҮГ, Ерөнхий инженер **Ж. Мөнхцэцэг**

- Айл өрхийн тоолуурын шугаманд үл буцах клапан хаалт хийх, суурилуулах
- Ус нөөцлөх санг эрүүл ахуйн шаардлага хангаж 3 сар тутам угаалгаж ариутгал хийх
- Айл өрхийн усны тоолуурын гэрчилгээг хангагч байгууллагад жагсаалтаар өгөх
- Гадна ШС-ний гүйцэтгэлийн зургийг өгөх
- Дүүргийн мэдээллийн санд шугам сүлжээний зургаа тусгуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Дулааны сүлжээ ТӨХК Ерөнхий инженер **А. Лхамсүрэн**

- Сэтэрт Групп ХХК -н гүйцэтгэсэн хотхоны нийт дулаан хангамжийн төвлөрсөн дулаан хангамжийг холбох дулааны техникийн нөхцлийг "БНДС" ТӨХК бөгөөд, барилгыг ДЭХ-д холбохдоо манайхаар хамтарч хийсэн тул цаашид ДЭХ түгээх, борлуулалтыг манайх хариуцах учир манайд байхаар тогтоож өгнө үү

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Онцгой байдлын ерөнхий газар, Барилгын зураг төсөл техникийн гүйцэтгэл хариуцсан ахлах мэргэжилтэн, Дэд хурандаа **Ч. Артаг**

- Зоорийн давхар болон техникийн давхарт зургийн дагуу гонхонд хаалга хийж өгөх
- Галын дотор усны даралтад цэгийг холбох тойныг солих
- Авто зогсоолд БНБД 21-05-10 -н дагуу тэмдэг, тэмдэглэгээг байрлуулах
- Зоорийн давхарт өөрчлөлтийн зураг гаргах, зохиогч тайлбар албан бичиг өгөх
- Оршин суугчдын тагтны ханыг зургийн дагуу байгаа эсэх. Зохиогч тайлбар өгөх
- Өгсөн үүрэг даалгаврыг албан бичиг болон фото зургаар өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Г ША
ГАЗА
уламж
улах н

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага **Б.Ганбаатар**

- Нийтийн авто зогсоолд ХБИ-ний машинд зориулсан зогсоолын өргөнийг 3м 95см тооцож хийнэ. Машин зогсох зай 2м 45см тэргэнцэртэй бууж, суух зай 1м 50см эргэх шугам татаж тусгайрлаж өгнө. Зогсоолын урд 1м 80см шон 30х45см самбар хийнэ
- Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан хөтөч замын эхлэл, төгсгөл, чиглэл заасан тэмдэглэгээтэй товгорой хавтанг замын эхлэл, төгсгөл, эргэлттэй хэсэгт сольж хийх
- Гадна налуу замын нэг талд нэмж нэг бариул хийх бариулын өргөнийг 3см ихгүй өргөнтэй бариулаар хийх 2 бариулын хоорондын зайг 90см суурилуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Багануур цахилгаан түгээх сүлжээ салбар **Л. Анхбаяр**

- ША-ны нэр хаяг хийх
- 0.4 кв-н оролт гаралтын кабелиудын төгсгөл дээр виркжүүлэх
- Дэд станцын болон ерөнхий шитны ухаалаг тоолуурт Здагч лац хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд авах саналтай байна.

Үндэсний Төв Архив, Зураг төслийн баримтын архивын ахлах архивч

Б. Оюунжаргал

- Архивт баримтаа баримт бүрдүүлэх жагсаалтын дагуу бүрэн бүрдүүлж өгөх
- Хувийн хэргийг жагсаалтын дагуу зөв дарааллан дотоод товъёг үйлдэн бүрэн бүрдэлтэй өгөх
- Ажлын зурагт нүүр хуудас хийж дугаарлан бүрэн бүрдэлтэй өгөх
- БУ-н тэмдэглэл дэвтэр бүрэн баталгаажуулж хуудас дугаарлан өгөх
- БУ-н ил далд ажлын акт, гэрэл зурагт дотоод товъёг үйлдэн бүрэн бүрдэлтэй өгөх
- ЦБУ-н өөрчлөлтийн зурагт нүүр хуудас хийж дугаарлан эх хувиар өгөх
- Барилгад хэрэглэсэн бараа материалын сертификат, чанарын гэрчилгээг дотоод товъёг хийж бүрэн өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд авах саналтай байна.

Ашиглалт хариуцах байгууллага БНДС – ТӨХК Ерөнхий инженер **А. Лхамсүрэн**

- Анх өгөгдсөн дулаан техникийн нөхцлөөр ДТТ (ЦТП)-10-аас 5 шугамаар (2р контор) тэжээгдэх ёстой. Одоогийн байдлаар ДТТ (ЦТП)-10-нь бүрэн ашиглалтанд ороогүй тул, түр зөвшөөрлөөр узель угсарч оруулсан. Энэ тухай хангагчтай тохиролцсон тухай албан бичиг, баримт шаардагатай /бүрдүүлсэн байх/
- Узелийн /халаалтын/ нэмэлт усны насосны цахилгаан соронзон хаалт, цахилгаан мэдрэгч /датчик/ байхгүй. Уг насосыг цахилгаан тэжээлд холбосон монтаж хийгдээгүй /хийх/
- Узельд хог шүүгчийн 2 талд манометр тавих
- Дулааны /гадна, дотор/ шугам хоолойн зураг төсөл манайд өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд авах саналтай байна.

Ашиглалт хариуцах байгууллага БНД Ус - ААТҮГ Ерөнхий инженер **Ж. Мөнхцэцэг**

- Ус нөөцлөх санг 3 сар тутам угаалгаж цэвэрлэгээ хийх зардлыг гүйцэтгэгч хариуцах
- Айл өрх бүрэн гүйцэд орохоос өмнөх усны тооцоог байрны оруулган тоолуураар тооцно
- Цэвэр усны босоо шугаманд даралт бууруулах вентель суурилуулах
- Хэрэглээний халуун усны босоо шугаманд хий авагч хийх
- Хэрэглээний халуун усны чанарын талаар ДС-т хандах
- Гадна шугамын засвар үйлчилгээ гүйцэтгэгч хариуцах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд авах саналтай байна.

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **А.Мөнгөн**

- БНБД-н 11-04-16 дагуу зохиогч зургийн өөрчлөлт, явцын хяналт дээрхи үүрэг даалгаврыг эцэслэн бичих
- БТХ-н 14.3, 14.6 дагуу гүйцэтгэгч чанарын баталгаа гаргах
- Давхар дундын шатны хонгилын цонхнуудад металл хамгаалалт хийх
- Гадна тохижилтын ажлыг батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу хийх.

Үүнд:

- ✓ Гадна зогсоолын тэмдэг, тэмдэглэгээ
- ✓ Хэвтээ болон босоо тэмдэг, тэмдэглэгээ
- ✓ Ногоон байгууламж /хугацаатай албан бичиг ирүүлэх
- ✓ Хог ангилан ялгах хогийн сав төлөвлөх, тоглоомын талбай
- Өөрчлөлтийн зураг хянуулах В1
- Засгийн газрын 2021 оны 212 тогтоолын 8.1 дэх заалтыг чанд баримтлах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Багануур дүүргийн 1 дүгээр хороо, Сэтэрт Групп ХХК-ийн захиалгатай, зорьтой 12 давхар, 1 блок, 8 автомашины дулаан зогсоолтой, 60 айлын орон сууцны зориулалттай барилгыг байнгын ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн:
Сэтэрт Групп ХХК-ийн
гүйцэтгэх захирал



(Г.Өлзийбуян)

